

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны  
Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны  
03 дугаар сарын 05 -ний өдрийн 947  
дугаар тушаалын хавсралт

**Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг  
сурталчлан таниулах ажлын удирдамж**

**ҮНДЭСЛЭЛ**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018 онд хийсэн “Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдагсдын 11.5 хувь нь гэр бүлийн уламжлалт угийн бичиг хөтөлдөг бол дийлэнх буюу 88.5 хувь нь хөтөлдөггүй байна.

Гэр бүлийн асуудлаар 2004, 2010, 2018 онд хийсэн судалгааны дүнг харьцуулан үзэхэд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2004 онд 8.2 хувь, 2010 онд 14.7 хувь байсан бол 2018 оны судалгаагаар 2010 оны түвшингээс 3.2 хувиар буурсан байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 13.0 хувь нь л өөрийн удам, намтраа сайн мэддэг бол 64.8 хувь нь ерөнхий мэдлэгээс цаашгүй, 22.2 хувь нь огт мэдэхгүй байна. Судалгаанд оролцогч гэр бүлийн 29.3 хувь нь төрөл, садантайгаа байнгын ойр дотно харилцаатай байдаг, 36.3 хувь нь холбоотой байдаг, 21.8 хувь нь зөвхөн баяр ёслол болон хурим, оршуулга зэрэг тэмдэглэлт үйлээр л холбогддог, 5.1 хувь нь бүр ямар ч холбоогүй гэжээ. Төрөл, садан хоорондын ойр дотно харилцаатай гэр бүлийн тоо өмнөх судалгаатай харьцуулахад бага хувиар нэмэгдсэн хэдий ч, зөвхөн тэмдэглэлт үйл явдлаар л уулздаг, огт харилцаагаа больсон гэх иргэдийн хандлага нэлээд хувиар нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

1996 онд батлагдсан Соёлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т “соёлын үнэт зүйл”-д “..... угийн бичиг. ... хамаарна” гэж, 3-т “соёлын үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг “соёлын байгууллага” гэж тодорхойлжээ. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.10-т заасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “соёл, урлагийг хөгжүүлэх асуудал, түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого”-ыг багтааснаар угийн бичгийн асуудлыг хариуцах төрийн захиргааны байгууллага нь тодорхой ч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас гадна манай яам угийн бичгийн асуудлыг хүн амын хүрээний гол асуудал хэмээн анхаарч ажилладаг. Яамнаас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, холбогдох төрийн бус байгууллагатай хамтран угийн бичиг хөтлөх асуудлаар үндэсний, салбар, аймаг, дүүргийн хэмжээнд 2017-2019 онд олон сургалт, семинар, зөвлөгөөн, өдөрлөг, үзэсгэлэн зохион байгуулсан.

УИХ-д өргөн бариад байгаа Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд гэрлэгчдийг эрүүл хүүхэд төрүүлэхэд бэлтгэх, ургийн өсөлт, бойжилтыг тогтмол хянуулах, угийн бичиг хөтлөх, өвлүүлэх, эцэг эхэд хүүхдэдээ

удам угсааг нь мэдүүлэх, цус ойртолтоос үүсэх үр дагаврыг тайлбарлан таниулахыг үүрэгжүүлсэн заалт тусгаад байна. Түүнчлэн Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт гэр бүлийн үнэт зүйлийг хамгаалах, хөгжүүлэх, дэвшилтэд уламжлал, зан заншлыг өвлүүлэх, угийн бичиг хөтлөхөд иргэдэд дэмжлэг үзүүлэх үүрэг тусгагдсан бол бүх шатны Засаг дарга нар угийн бичиг хөтлүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах юм.

Судалгааны дүнгээс харахад өнгөрсөн жилүүдэд олон сургалт, семинар, зөвлөгөөн, өдөрлөг, үзэсгэлэн зохион байгуулсан хэдий ч угийн бичиг хөтлөх өв уламжлал төдийлөн сайн сэргэхгүй байгаа нь угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, тэднийг арга зүйгээр байнга хангах шаардлага байсаар байгааг харуулж байна.

Иймд, угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах байнгын арга зүй бий болгох зорилгоор техникийн дэвшлийг ашиглан давтамжтай нэвтрүүлж байх үүднээс цуврал баримтат кино хийж, олон нийтэд түгээхийг үр дүнтэй гэж үзлээ.

### **ЗОРИЛГО:**

Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, иргэдийг арга зүйгээр хангах нь олон нийтийг угийн бичгээ хөтлөх эрмэлзлэл, сонирхолтой болгож, хөтөлдөг болгохоос гадна дараах ач холбогдолтой:

1. Монгол Улсын хүн амыг өсгөх бодлогыг дэмжих,
2. Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, цус ойртолтын болзошгүй аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх,
3. Цус ойртолтоос үүсэх үр дагаврыг олон нийтэд тайлбарлан таниулах, угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлыг ойлгуулах,
4. Гэр бүлийн үнэт зүйлийг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, дэвшилтэд уламжлал, зан заншлыг өвлүүлэх,
5. Эцэг эх хүүхэддээ удам угсааг нь мэдүүлэх, ах дүүс, хамаатан садангаа танилцуулдаг, уулзуулдаг болох.

### **ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, арга зүйгээр хангах зорилгоор баримтат кино хийх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. Угийн бичиг хөтөлж буй одоогийн арга зүй, нөхцөл байдлыг судлах,
2. Иргэдийн угийн бичгээ хөтлөхгүй байгаа шалтгаан, учирч буй бэрхшээлийг судлах,
3. Судалгааг үндэслэн угийн бичиг хөтлөх ач холбогдлыг сурталчлан таниулах, хөтлөх арга зүйг түгээх зорилгоор киноны агуулгыг гаргах,
4. Баримтат кино хийх явцад угийн бичиг хөтлөлтийн судалгаа хийн ажиллаж буй орон нутгийн иргэдэд ухуулга, нөлөөллийн ажил хийх,

5. Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх, цус ойртолтыг үгүй болгох талаар эрдэмтэн судлаачидтай уулзаж, тэдний санал бодлыг олон нийтэд хүргэх үүднээс баримтат киноны агуулгад оруулах,
6. Угийн бичиг хөтлөх ач холбогдлыг сурталчлан таниулах, арга зүйг олон нийтэд сурталчлах чиглэлээр цуврал баримтат кино хийх,
7. Судалгааг үндэслэн угийн бичиг хөтлөх журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах.

Эдгээр үйл ажиллагааг мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

## **БҮТЭЭГДЭХҮҮН**

Энэхүү ажлын үр дүнд дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө:

1. Угийн бичиг хөтлөх ач холбогдлыг сурталчлан таниулах, арга зүйг олон нийтэд сурталчлах зорилготой гурван цуврал баримтат кино,
2. Угийн бичиг хөтлөх журамд өөрчлөлт оруулах санал /журмын шинэчилсэн төсөл/.

Хүлээлгэн өгсөн бүтээгдэхүүн нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны өмч байна.

## **ХУГАЦАА**

Энэхүү ажлыг 2020 оны 3 дугаар сарын 17-нээс эхлэн 5 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд хийхээр төлөвлөж байна.

## **ХҮРЭХ ҮР ДҮН:**

Энэхүү ажлыг хэрэгжүүлснээр угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, иргэдийг арга зүйгээр хангах зорилгод хүрэхээс гадна нийгэмд дараах эерэг үр дүнг үзүүлнэ:

- Иргэд, гэр бүл ургийн бичгээ хөтөлдөг болж, угийн бичгийн хөтлөлтийн түвшинг улсын хэмжээнд сайжирснаар цус ойртолт үгүй болоход нөлөөлнө.
- Залуучууд гэр бүлийн үнэ цэнийг ойлгож, гэр бүл болоход анхааралтай хандаж, ах дүү, хамаатан садан, ураг төрлөө таньж мэдэх эрмэлзлэлтэй болно.